



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2018 оны 08 сарын 31 өдөр

Дугаар А/99

Улаанбаатар хот

Арилжаанд оролцох эрхийг
сэргээх тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, "Монголын хөрөнгийн бирж" төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.11 дэх заалт, "Үнэт цаасны арилжаанд оролцох эрх олгох журам"-ын 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт "Гаули ҮЦК" ХХК-ийн 2018 оны 18/142 дугаартай албан хүсэлтийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2018 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн А/79 дугаар тушаалаар арилжаанд оролцох эрхийг түдгэлзүүлсэн "Гаули ҮЦК" ХХК-ийн ажилтан /Ц.Чанцал/-ын үнэт цаасны арилжаанд оролцох эрхийг 2018 оны 08 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн сэргээсүгэй.
2. Цаашид хууль тогтоомж, журам заавар болон "Монголын хөрөнгийн бирж" төрийн өмчит хувьцаат компанийтай байгуулсан "Гишүүнчлэлийн гэрээ"-гээр хүлээсэн үүргээ тогтмол биелүүлэн ажиллахыг "Гаули ҮЦК" ХХК /Ц.Чанцал/-д анхааруулсугай.
3. Үнэт цаасны арилжааны программд нэвтрэх эрхийг сэргээхийг Үйл ажиллагааны газрын Арилжааны алба /Д.Алдармаа/-нд, тушаалын биелэлтэд Хяналт тавьж ажиллахыг Хяналт, зохицуулалтын газрын Хяналт шинжилгээний алба /Д.Баттулга/-нд даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Х.АЛТАЙ



000614